

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/02-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	15-17
4.1 Ерөнхий зүйл	15-16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16-17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДЭЛГЭРЦЭЦЭГ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/02-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд эрүүл мэндийн байгууллагуудаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 40 албан хаагчид 750,682.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 118 албан хаагчид 578,693.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 20 албан хаагчид 41,925.0 мянган төгрөг зэрэг нийт 1,371,300.5 мянган төгрөгийн тэтгэмж, урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд оны эцэст ЭМЯ-наас 70,000.0 мянган төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангаас 20,618.1 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн боловч байгууллагын дарга үүрэгт ажлаас чөлөөлөгдөн, гүйлгээ хийх

боломжгүй байдалд хүрсний улмаас зарцуулагдаагүй үлдсэн 88,224.4 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлснээс хойш “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон бусад холбогдох хууль эрхийн актуудад хийгдсэн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газар нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,158,854.19	114,665,905.19
33	АВЛАГА	38,408,498.00	88,224,449.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	38,408,498.00	88,224,449.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,750,356.19	26,441,456.19
35100	Түүхий эд материал	12,448,187.19	15,139,287.19
35110	Тусгай зориулалттай материал	6,638,287.19	9,371,787.19
35130	Эм боох материал	5,809,900.00	5,767,500.00
35400	Хангамжийн материал	11,302,169.00	11,302,169.00
35410	Бичиг хэргийн материал	296,149.00	296,149.00
35420	Аж ахуйн материал	11,006,020.00	11,006,020.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	666,638,493.64	591,908,719.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	666,638,493.64	591,908,719.43
39200	Биет хөрөнгө	403,321,293.64	328,591,519.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	147,594,083.00	147,594,083.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(31,439,154.69)	(38,817,342.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216,505,880.00	216,505,880.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(173,533,657.88)	(193,366,991.24)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	413,729,161.73	419,344,891.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(240,963,454.58)	(289,066,453.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	157,631,990.62	162,238,218.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(130,569,566.84)	(136,167,831.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	47,409,960.00	47,409,960.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,043,947.72)	(7,082,895.48)
39300	Биет бус хөрөнгө	263,317,200.00	263,317,200.00
39301	Програм хангамж	7,479,711.40	7,479,711.40
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,479,711.40)	(7,479,711.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	263,317,200.00	263,317,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	728,797,347.83	706,574,624.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	43,042,556.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,042,556.00	-
41300	Өглөг	43,042,556.00	-
41360	Бусад өглөг	43,042,556.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	38,408,498.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,634,058.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	685,754,791.83	706,574,624.62
51	Засгийн газрын хувь оролцоо	685,754,791.83	706,574,624.62
51100	Засгийн газрын оруулсан капитал	140,566,428.00	140,566,428.00
5E+05	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	140,566,428.00	140,566,428.00
51200	Хуримтлагдсан үр дүн	481,088,298.83	501,908,131.62
51210	Өмнөх үеийн үр дүн	493,192,159.71	481,088,298.83
51220	Тайлант үеийн үр дүн	(12,103,860.88)	20,819,832.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,100,065.00	64,100,065.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	728,797,347.83	706,574,624.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,745,505,657.92	3,317,731,596.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,360,527,360.92	834,094,959.63
120	Нийтлэг татварын бус орлого	1,360,527,360.92	834,094,959.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,085,000.00	2,670,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,085,000.00	2,670,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	69,810,685.00	4,722,258.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,287,631,675.92	826,702,701.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,384,978,297.00	2,483,636,636.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,221,463,600.00	2,313,356,750.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,221,463,600.00	2,313,356,750.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	163,514,697.00	170,279,886.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	36,353,900.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,633,120.00	80,219,488.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,527,677.00	90,060,398.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,757,609,518.80	3,296,911,763.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,757,609,518.80	3,296,911,763.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,081,124,272.00	1,753,024,171.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,668,809.20	626,224,639.32
210101	Үндсэн цалин	267,705,869.20	393,535,913.74
210102	Нэмэгдэл	80,211,883.00	149,493,119.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,845,664.00	34,135,469.88
210104	Урамшуулал	37,905,393.00	49,060,136.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,550,483.00	79,068,618.48
210201	Тэтгэврийн даатгал	34,248,114.11	53,539,908.61
210202	Тэтгэмжийн даатгал	3,781,548.42	6,964,525.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,383,658.93	4,959,936.99
210204	Ажилгүйдлийн даатгал	737,441.72	1,141,577.69
210205	Эрүүл мэндийн даатгал	7,399,719.82	12,462,670.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,679,700.00	9,136,184.71
210301	Гэрэл, цахилгаан	2,412,402.00	246,809.71
210302	Түлш, халаалт	7,267,298.00	8,889,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,917,230.00	25,053,289.45
210401	Бичиг хэрэг	6,055,687.00	3,807,600.00
210402	Тээвэр, шатахуун	20,884,337.00	13,336,394.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,214,556.00	4,108,520.45
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,760,850.00	3,800,775.00
210408	Бараа материал акталсны зардал	1,800.00	-
2105	Нормативт зардал	1,233,913,482.00	831,961,813.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,232,393,482.00	830,318,413.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,520,000.00	1,643,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,088,420.00	9,650,810.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,459,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,331,000.00	-
210604	Урсгал засвар	37,298,420.00	9,650,810.00

2107	Томилолт, зочны зардал	12,290,200.00	13,525,900.00
210702	Дотоод албан томилолт	12,290,200.00	13,525,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,032,029.00	7,623,410.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,659,769.00	2,438,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,092,200.00	3,092,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,060.00	134,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	162,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,051,000.00	1,880,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	279,983,918.80	150,779,506.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	194,312,735.73	68,746,086.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,045,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,626,183.07	82,033,420.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,676,485,246.80	1,543,887,591.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,506,096,186.00	1,371,300,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	619,720,586.00	750,682,480.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	839,078,200.00	578,693,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,297,400.00	41,925,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	170,389,060.80	172,587,111.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	170,389,060.80	172,587,111.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(12,103,860.88)	20,819,832.79
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(12,103,860.88)	20,819,832.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,430,121,768.00	2,486,306,636.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,925,000.00	2,670,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,925,000.00	2,670,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,925,000.00	2,670,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,925,000.00	2,670,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,427,196,768.00	2,483,636,636.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,221,463,600.00	2,313,356,750.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,221,463,600.00	2,313,356,750.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,733,168.00	170,279,886.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,132,648.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,633,120.00	80,219,488.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,967,400.00	90,060,398.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,429,397,468.00	2,480,806,936.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,429,397,468.00	2,480,806,936.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	714,503,773.20	848,694,895.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,668,809.20	626,224,639.32
210101	Үндсэн цалин	243,364,669.20	374,879,337.04
210102	Нэмэгдэл	102,093,747.00	166,154,697.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,305,000.00	36,130,468.58
210104	Урамшуулал	37,905,393.00	49,060,136.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,550,483.00	79,068,618.48
210201	Тэтгэврийн даатгал	33,205,244.88	53,539,908.61
210202	Тэтгэмжийн даатгал	4,138,767.90	6,964,525.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,069,308.68	4,959,936.99

210204	Ажилгүйдлийн даатгал	737,441.72	1,236,747.71
210205	Эрүүл мэндийн даатгал	7,399,719.82	12,367,500.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,679,700.00	7,744,184.71
210301	Гэрэл, цахилгаан	2,412,402.00	246,809.71
210302	Түлш, халаалт	7,267,298.00	7,497,375.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,805,610.00	29,391,009.45
210401	Бичиг хэрэг	3,143,500.00	4,453,860.00
210402	Тээвэр, шатахуун	20,091,517.00	19,573,664.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,976,193.00	4,102,360.45
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,594,400.00	1,261,125.00
2105	Нормативт зардал	35,660,087.00	1,033,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,660,087.00	655,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	378,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,967,603.00	15,114,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,459,000.00	2,788,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,331,000.00	1,265,000.00
210604	Урсгал засвар	42,177,603.00	11,060,610.00
2107	Томилолт, зочны зардал	12,290,200.00	13,332,000.00
210702	Дотоод албан томилолт	12,290,200.00	13,332,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,447,860.00	7,834,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,925,000.00	2,649,850.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,092,200.00	3,092,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,060.00	134,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	162,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,201,600.00	1,880,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,433,421.00	68,952,624.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,388,421.00	68,403,624.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,045,000.00	549,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,714,893,694.80	1,632,112,040.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,506,096,136.00	1,371,300,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	619,720,586.00	750,682,480.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	839,078,150.00	578,693,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	47,297,400.00	41,925,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	208,797,558.80	260,811,560.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	170,389,060.80	172,587,111.54
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	38,408,498.00	88,224,449.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	724,300.00	5,499,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	724,300.00	5,499,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	724,300.00	5,499,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	724,300.00	5,499,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	724,300.00	5,499,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(724,300.00)	(5,499,700.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	493,192,159.71	697,858,652.71
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,103,860.88)	(12,103,860.88)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	481,088,298.83	685,754,791.83
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	481,088,298.83	685,754,791.83
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	481,088,298.83	685,754,791.83
19	Тайлант үеийн үр дүн	-	-	20,819,832.79	20,819,832.79
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	501,908,131.62	706,574,624.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,373,451,300.00	2,143,439,638.96	(230,011,661.04)	90.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,373,451,300.00	2,143,439,638.96	(230,011,661.04)	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,881,700.00	772,139,158.96	(157,742,541.04)	83.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,664,900.00	626,224,639.32	(127,440,260.68)	83.1
210101	Үндсэн цалин	420,073,000.00	374,879,337.04	(45,193,662.96)	89.2
210102	Нэмэгдэл	238,321,500.00	166,154,697.08	(72,166,802.92)	69.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,745,000.00	36,130,468.58	(5,614,531.42)	86.6
210104	Урамшуулал	53,525,400.00	49,060,136.62	(4,465,263.38)	91.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,208,000.00	79,068,618.48	(15,139,381.52)	83.9
210201	Тэтгэврийн даатгал	64,061,500.00	53,539,908.61	(10,521,591.39)	83.6
210202	Тэтгэмжийн даатгал	7,536,600.00	6,964,525.11	(572,074.89)	92.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,029,300.00	4,959,936.99	(1,069,363.01)	82.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,300.00	1,236,747.71	(270,552.29)	82.1
210205	Эрүүл мэндийн даатгал	15,073,300.00	12,367,500.06	(2,705,799.94)	82.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,647,400.00	7,744,184.71	(903,215.29)	89.6
210301	Гэрэл, цахилгаан	1,100,000.00	246,809.71	(853,190.29)	22.4
210302	Түлш, халаалт	7,547,400.00	7,497,375.00	(50,025.00)	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	22,586,800.00	21,561,621.45	(1,025,178.55)	95.5
210401	Бичиг хэрэг	4,387,200.00	4,453,860.00	66,660.00	101.5
210402	Тээвэр, шатахуун	12,112,400.00	12,181,301.00	68,901.00	100.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,048,400.00	4,102,360.45	(946,039.55)	81.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	266,200.00	-	(266,200.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	772,600.00	824,100.00	51,500.00	106.7
2105	Нормативт зардал	1,034,000.00	1,033,400.00	(600.00)	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	655,600.00	655,000.00	(600.00)	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	378,400.00	378,400.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,450,900.00	9,106,150.00	(6,344,750.00)	58.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,052,900.00	1,997,900.00	(1,055,000.00)	65.4
210602	Тавилга	2,831,900.00	2,099,900.00	(732,000.00)	74.2

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,265,500.00	1,265,000.00	(500.00)	100.0
210604	Урсгал засвар	8,300,600.00	3,743,350.00	(4,557,250.00)	45.1
2107	Томилолт, зочны зардал	13,944,800.00	7,919,400.00	(6,025,400.00)	56.8
210702	Дотоод албан томилолт	13,944,800.00	7,919,400.00	(6,025,400.00)	56.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,129,400.00	7,284,310.00	(845,090.00)	89.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,102,500.00	2,099,850.00	(2,650.00)	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	598,600.00	-	(598,600.00)	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,092,000.00	3,092,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,100.00	134,860.00	(156,240.00)	46.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,600.00	77,000.00	(63,600.00)	54.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,904,600.00	1,880,600.00	(24,000.00)	98.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,215,500.00	12,196,835.00	(18,665.00)	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,647,900.00	11,647,835.00	(65.00)	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	567,600.00	549,000.00	(18,600.00)	96.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,443,569,600.00	1,371,300,480.00	(72,269,120.00)	95.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,443,569,600.00	1,371,300,480.00	(72,269,120.00)	95.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	822,948,200.00	750,682,480.00	(72,265,720.00)	91.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	578,693,000.00	578,693,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,928,400.00	41,925,000.00	(3,400.00)	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,373,451,300.00	2,316,026,750.50	(57,424,549.50)	97.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,368,951,300.00	2,313,356,750.50	(55,594,549.50)	97.7
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,368,951,300.00	2,313,356,750.50	(55,594,549.50)	97.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,500,000.00	2,670,000.00	(1,830,000.00)	59.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	2,670,000.00	(1,830,000.00)	59.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	77.00	71.00	(6.00)	92.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38.00	35.00	(3.00)	92.1
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	30.00	(3.00)	90.9
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	35.00	(3.00)	92.1
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	35.00	32.00	(3.00)	91.4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3.00	3.00	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	49.00	49.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,279,886.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170,279,886.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,055,437.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,829,388.00
210402	Тээвэр, шатахуун	7,392,363.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	437,025.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,507,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,190,400.00
210604	Урсгал засвар	7,317,260.00
2107	Томилолт, зочны зардал	5,412,600.00
210702	Дотоод албан томилолт	5,412,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	550,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,755,789.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,755,789.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,224,449.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,224,449.00
21335	Улсын төсвөөс олгосон нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	88,224,449.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,279,886.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,279,886.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,219,488.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	90,060,398.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын бие бялдрыг хөгжүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлснээр хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах,
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах,
- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар

бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 дугаар тушаалаар ЭМЯ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2010 оноос хойш “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д болон бусад холбогдох хууль, эрхийн актуудад шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлтүүд хийгдсэн тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,222.7 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	38,408.5	88,224.4	49,815.9
Бараа материал	23,750.4	26,441.5	2,691.1
Үндсэн хөрөнгө	666,638.4	591,908.7	(74,729.7)
Нийт хөрөнгө	728,797.3	706,574.6	(22,222.7)
Өр төлбөр	43,042.5	-	(43,042.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	685,754.8	706,574.6	20,819.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	728,797.3	706,574.6	(22,222.7)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл болж 88,224.4 мянган төгрөг болж, 49,815.9 мянган төгрөгөөр өссөн нь оны эцэст тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМЯ-наас 70,000.0 мянган төгрөг, НҮБ-ын хүүхдийн сангаас 20,618.1 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсний зарцуулагдаагүй үлдэгдэл болох 88,224.4 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлснээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 591,908.7 мянган төгрөг болж, 74,729.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан элэгдлээс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2023 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,295,887.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,500.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,300,387.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,261.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,369.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 7,713.6 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 8,961.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 26,369.3 төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,894.2 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 6,410.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж 2,297,019.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт цалин, нийгмийн даатгалын зардлыг 76,432.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийж, 2,373,451.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,368,951.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,313,356.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоор 2,670.0 мянган төгрөгийг зэрэг нийт 2,316,026.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,143,439.6 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 142,579.6 мянган

төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 6,344.7 мянган төгрөг зэргээр хэмнэж нийт 172,587.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	969,328.4	757,821.3	(211,507.1)	78.2
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг /80802/	1,387,975.0	1,371,300.5	(16,674.4)	98.8
3	Хөтөлбөр, төслийн дотоод урсгал /83112/	11,647.9	11,647.8	(0.1)	100
4	Үндсэн үйл ажиллагаа	4,500.0	2,670.0	(1,830.0)	59.3
	Нийт	2,373,451.3	2,143,439.6	(230,011.7)	90.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “*нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна*” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн өмнөх оны үлдэгдэл болох 38,408.5 мянган төгрөг, ЭМЯ-наас 72,811.5 мянган төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 30,263.7 мянган төгрөг, НҮБ-ийн хүүхдийн сангаас 20,618.1 мянган төгрөг, ХӨСҮТ-өөс 7,408.0 мянган төгрөгийн зэрэг нийт 131,871.4 мянган төгрөгийн орлого төвлөрч, 43,647.0 мянган төгрөгийг зарцуулан, 88,224.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “*Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана*” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримт, үндсэн хөрөнгийн бүртгэл болон бараа материалын данстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 69 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,757,609.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 37,576.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын нийт зардал нь өмнөх оноос буурсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,255,585.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **32,555.8** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Данс бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон,
- Үндсэн болон шуурхай үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд зориулан гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,*

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус төвийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 111,602.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс худалдан авалтыг баримтаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж, анхан шатны баримтыг бүрдэл дутуу, түлш, шатахууны зарцуулалтыг бөөн дүнгээр бүртгэсэн зөрчлүүдэд 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	24,648.9	1	24,648.9	100
Зөвлөмж	1	60,952.5	1	60,952.5	100
	1	-	1	-	100
	1	26,001.3	1	26,001.3	100
Нийт дүн	4	111,602.7	4	111,602.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **3,414.1** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3,078.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 335.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн **1,519.0** мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 40.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр **1,559.4** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Д.Нямаад 882.1 мянган төгрөг,
- Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч бөгөөд төлөвлөлт, эдийн засаг хариуцсан мэргэжилтэн У.Ууган-Эрдэнэд 398.2 мянган төгрөг,
- Нярав Д.Ононд 279.1 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Томилолтын хуудасгүй буюу бүрдэл дутуу анхан шатны баримтаар албан томилолтын зардалд **335.7** мянган төгрөг олгож, бүртгэл тайланд тусгасан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 77 нэр төрлийн хөрөнгийг /Нийт хөрөнгийн 54.2 хувь/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: ЭМЯ-наас үнэ төлбөргүй шилжиж ирсэн вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийн тоо ширхгийг бөөн дүнгээр орлого авч, зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн программд бичилт хийж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоолны хөнгөлөлтийг давхардуулсан	1	1,519.0	1	1,519.0								
Урамшуулал давхардуулан олгосон	1	1,559.4	1	1,559.4								
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар албан томилолтын зардал олгосон	1	335.7					1	335.7				
Хөрөнгийг дахин үнэлээгүй	1	-					1	-				
БМ-ын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй	1	-					1	-				
Дүн	5	3,414.1	2	3,078.4			3	335.7				